




ӨНДӨР ХУРДНЫ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ



ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Дугаар: ТН-А249/2019

2019/04/30

Захиалагч байгууллага: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Хэрэглэгчийн нэр: О.НЯМБАТ

Харилцах утас: 327575

- 1. Байршил:** **КШТ 32-н хүрээнд:**
1. ЧД 2-р хорооны камержуулалт **КШТ 32-н хүрээнд:**
 2. ЧД 5-р хорооны камержуулалт **КШТ 36-н хүрээнд:**
 3. ЧД 7-р хорооны камержуулалт **КШТ 36-н хүрээнд:**
 4. ЧД 8-р хорооны камержуулалт **КШТ 32-н хүрээнд:**
 5. ЧД 9-р хорооны камержуулалт

2. Холбооны хэрэгцээ: Сувагчлалаар шилэн кабель татах

1. Сувагчлалын урт	1314 м
Худгийн тоо	24 ш
2. Сувагчлалын урт	303 м
Худгийн тоо	9 ш
3. Сувагчлалын урт	17 м
Худгийн тоо	1 ш
Баганы тоо	36 ш
4. Сувагчлалын урт	0 м
Худгийн тоо	1 ш
Баганы тоо	25 ш
5. Сувагчлалын урт	99 м
Худгийн тоо	4 ш
Баганы тоо	68 ш

3. Техникийн онцгой нөхцөл: Харилцаа Холбооны Зохицуулах хорооноос олгогдсон үндсэн сүлжээ байгуулах бүрэн эрхийнхээ дагуу холбоожуулах техникийн нөхцлийг зөвхөн МХС ХХК олгох бөгөөд техникийн нөхцөлгүйгээр холбооны бүх төрлийн үйлчилгээний зориулалттайгаар кабель татах болон шилжүүлсэн тохиолдолд уг барилга объектыг техникийн болон улсын комиссоор хүлээн авахгүй болно.

4. Техникийн үндсэн нөхцөл:

- 4.1. Шилэн кабель татахдаа худагт нөөц үлдээхгүй бөгөөд төгсгөлийн төхөөрөмж байрлуулах байрлалд нөөцийг авах шаардлагатай.
- 4.2. Техникийн нөхцлийн дагуу угсралтын ажлыг гүйцэтгэж техникийн актыг хүлээлгэн өгөөгүй тохиолдолд тухайн чиглэлийн худаг сувагчлалыг шилжүүлэх, гадны гэмтэл саатал гарсан тохиолдолд гарах зардал болон хариуцлагыг МХС ХХК хариуцахгүй болно.
- 4.3. Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос олгосон холбооны кабель шугамын угсралт хийх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх шаардлагатай.

5. Зураг төсөвт зайлшгүй тусгах шаардлагатай технологийн онцгой нөхцлүүд:

- 5.1. Шинээр хийгдэх кабель, шугам болон худаг сувагчлалын төсвийг зохиохдоо Монгол улсын стандарт MNS 5276:2003, MNS 5279:2003, MNS 5280:2003, MNS 5277:2003 тоот ерөнхий шаардлагууд болон ДБХ-ийн сайдын 1995 оны 127-р тушаалаар батлагдсан зааврыг баримтлан гүйцэтгэх.
- 5.2. Кабель татах трассын зураг гаргахдаа шаардлагатай худагт кабелийн болон муфтны тавиур хийх ажлыг тусгаж өгөх.

6. Угсралтын ажлын үед тавигдах нөхцлүүд:

- 6.1. Шинээр татсан кабельд бирк бүрэн хийсэн байх ба кабель татах тохиолдолд худагт муфтыг хийх тохиолдолд муфтыг худгийн хананд тусгай тавиур хийж байрлуулсан байх.
- 6.2. Угсралтанд ажлын явцад захиалагч ашиглалтын байгууллагатай хамтарч хяналт тавьж угсралтын технологийн шаарлагыг бүрэн хангуулсан байх.
- 6.3. Угсралтын ажил эхлэхийн өмнө тус газрын харъяалагдах шугам кабелийн тасагт мэдэгдэж кабель татах янданг заалган түүний дагуу гүйцэтгэх ба гүйцэтгэлийг БГТ-н техникчээр хянуулан актанд тусгуулна. Хэрэв заагдсан яндангаар татаагүй нөхцөлд ашиглалтын явцад шилжүүлэх шаардлага гарвал гарах зардлыг гүйцэтгэгч тал хариуцна.

7. Техникийн нөхцлийг НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР-н Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын 2019 оны 03 сарын 28-ний өдрийн 3/529 тоот албан бичгийг үндэслэн олгов.

~~8. Угсралтын ажил дууссаны дараа САД-н зураг, кабель татсан яндангийн паспорт техникийн актыг УБ Хотын сүлжээний газарт хүлээлгэн өгөх шаардлагатай.~~

9. ЭНЭХҮҮ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ НЬ ОЛГОСОН ӨДРӨӨС ХОЙШ 1 ЖИЛИЙН ХУГАЦААНД ХҮЧИНТЭЙ.


Техникийн нөхцөлтэй танилцсан:
УБХСГ-ын Дарга

2



Н.МАНДАХБААТАР

Техникийн нөхцлийг хянасан:
УБХСГ-ын Ерөнхий инженер



Н.НАРАНБААТАР


Боловсруулсан:
УБХСГ-ын БТТ-ийн ахлах инженер



Д.БАЛМАА



ӨНДӨР ХУРДНЫ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ



ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Дугаар: ТН-А250/2019

2019/04/30

Захиалагч
байгууллага: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗАР
Хэрэглэгчийн нэр: О.НЯМБАТ
Харилцах утас: 327575

1. Байршил: КШТ 32-н хүрээнд:
6. ЧД 11-р хорооны камержуулалт
КШТ 32-н хүрээнд:
7. ЧД 13-р хорооны камержуулалт
КШТ 35-н хүрээнд:
8. ЧД 14-р хорооны камержуулалт
КШТ 35-н хүрээнд:
9. ЧД 15-р хорооны камержуулалт
КШТ 35-н хүрээнд:
10. ЧД 17-р хорооны камержуулалт
КШТ 35-н хүрээнд:
11. ЧД 18-р хорооны камержуулалт

2. Холбооны хэрэгцээ: Сувагчлалаар шилэн кабель татах

6 Сувагчлалын урт	0 м
Худгийн тоо	0 ш
Баганы тоо	84 ш
7. Сувагчлалын урт	1392 м
Худгийн тоо	18 ш
Баганы тоо	29 ш
8. Сувагчлалын урт	83 м
Худгийн тоо	5 ш
Баганы тоо	46 ш
9. Сувагчлалын урт	546 м
Худгийн тоо	12 ш
Баганы тоо	32 ш
10. Сувагчлалын урт	0 м
Худгийн тоо	0 ш
Баганы тоо	52 ш
11. Сувагчлалын урт	1839 м
Худгийн тоо	25 ш
Баганы тоо	56 ш

3. **Техникийн онцгой нөхцөл:** Харилцаа Холбооны Зохицуулах хорооноос олгогдсон үндсэн сүлжээ байгуулах бүрэн эрхийнхээ дагуу холбоожуулах техникийн нөхцлийг зөвхөн МХС ХХК олгох бөгөөд техникийн нөхцөлгүйгээр холбооны бүх төрлийн үйлчилгээний зориулалттайгаар кабель татах болон шилжүүлсэн тохиолдолд уг барилга объектыг техникийн болон улсын комиссоор хүлээн авахгүй болно.

4. **Техникийн үндсэн нөхцөл:**

- 4.1. Шилэн кабель татахдаа худагт нөөц үлдээхгүй бөгөөд төгсгөлийн төхөөрөмж байрлуулах байрлалд нөөцийг авах шаардлагатай.
- 4.2. Техникийн нөхцлийн дагуу угсралтын ажлыг гүйцэтгэж техникийн актыг хүлээлгэн өгөөгүй тохиолдолд тухайн чиглэлийн худаг сувагчлалыг шилжүүлэх, гадны гэмтэл

саатал гарсан тохиолдолд гарах зардал болон хариуцлагыг МХС ХХК хариуцахгүй болно.

4.3. Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос олгосон холбооны кабель шугамын угсралт хийх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх шаардлагатай.

5. Зураг төсөвт зайлшгүй тусгах шаардлагатай технологийн онцгой нөхцлүүд:

- 5.1. Шинээр хийгдэх кабель, шугам болон худаг сувагчлалын төсвийг зохиохдоо Монгол улсын стандарт MNS 5276:2003, MNS 5279:2003, MNS 5280:2003, MNS 5277:2003 тоот ерөнхий шаардлагууд болон ДБХ-ийн сайдын 1995 оны 127-р тушаалаар батлагдсан зааврыг баримтлан гүйцэтгэх.
- 5.2. Кабель татах трассын зураг гаргахдаа шаардлагатай худагт кабелийн болон муфтны тавиур хийх ажлыг тусгаж өгөх.

6. Угсралтын ажлын үед тавигдах нөхцлүүд:


- 6.1. Шинээр татсан кабельд бирк бүрэн хийсэн байх ба кабель татах тохиолдолд худагт муфтыг хийх тохиолдолд муфтыг худгийн хананд тусгай тавиур хийж байрлуулсан байх.
- 6.2. Угсралтанд ажлын явцад захиалагч ашиглалтын байгууллагатай хамтарч хяналт тавьж угсралтын технологийн шаарлагыг бүрэн хангуулсан байх.
- 6.3. Угсралтын ажил эхлэхийн өмнө тус газрын харъяалагдах шугам кабелийн тасагт мэдэгдэж кабель татах янданг заалган түүний дагуу гүйцэтгэх ба гүйцэтгэлийг БГТ-н техникчээр хянуулан актанд тусгуулна. Хэрэв заагдсан яндангаар татаагүй нөхцөлд ашиглалтын явцад шилжүүлэх шаардлага гарвал гарах зардлыг гүйцэтгэгч тал хариуцна.

7. Техникийн нөхцлийг НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР-н Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын 2019 оны 03 сарын 28-ний өдрийн 3/529 тоот албан бичгийг үндэслэн олгов.

8. Угсралтын ажил дууссаны дараа САД-н зураг, кабель татсан яндангийн паспорт техникийн актыг УБ Хотын сүлжээний газарт хүлээлгэн өгөх шаардлагатай.


9. ЭНЭХҮҮ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ НЬ ОЛГОСОН ӨДРӨЭС ХОЙШ 1 ЖИЛИЙН ХУГАЦААНД ХҮЧИНТЭЙ.

Техникийн нөхцөлтэй танилцсан:
УБХСГ-ын Дарга



Н.МАНДАХБААТАР

Техникийн нөхцлийг хянасан:
УБХСГ-ын Ерөнхий инженер



Н.НАРАНБААТАР

Боловсруулсан:
УБХСГ-ын БТТ-ийн ахлах инженер

Д.БАЛМАА


БАТЛАВ.
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА А. ДАМЦАГДОРЖ


2019 оны 07 дугаар сарын 01 өдөр

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ХЯНАЛТЫН
КАМЕР СУУРИЛУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

Дүүргийн нутаг дэвсгэрт хяналтын камер суурилуулах ажлыг хийхдээ дараах шаардлагыг баримтална. Үүнд:

1. Хяналтын камер нь 360 градус эргэж хяналт хийдэг, 180 градус харах өргөн өнцгийн болон энгийн чигийн камер гэсэн 3 төрлийн хяналтын камер суурилуулна.
2. 360 градус эргэдэг болон 180 градусын өргөн өнцгийн хяналтын камерууд нь хослон ажиллаж хяналт хийхээр шийдлийг боловсруулна.
3. Сүлжээ нь сувагчлалаар болон агаараар татах зориулалтын 8 шөрмөс бүхий шилэн кабел байна.
4. Дотоод сүлжээний кабел нь гадна зориулалтын STP Cat6E кабел байна.
5. Тэжээлийн утас нь ПВ 2*2.5тт утас байна.
6. Холбооны болон цахилгааны кабел нь далд байх, хамгаалагдсан хоолойд хийсэн байх.
7. Хяналтын камерын цэгийн шон нь төвийн бүс буюу 1-6 дугаар хороонд 6м өндөртэй, гэр хорооллын бүс буюу 7-19 дүгээр хороонд 9м өндөртэй 1.5 урт гартай төмөр шон байна.
8. Төхөөрөмжийн хайрцаг нь 50*40*30 8 мм зузаантай төмөр хийц бүхий тоос шороо, ус чийгний хамгаалалттай зориулалтын хайрцаг байна.
9. Хяналтын камерын суурилуулах цэгүүдээс хамааран хяналтын камерын хяналтыг дүүргийн Цагдаагийн 1, 2 дугаар хэлтсийн теле-хяналтын камерын өрөөнд холбоно.

Хянасан: Мэдээллийн технологи, олон нийттэй харилцах албаны дарга  Б.Лхагваням

Боловсруулсан: Дотоод сүлжээ хариуцсан мэргэжилтэн  Л.Мөнх-Эрдэнэ

ХЯНАЛТЫН КАМЕРЫН АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Сүлжээний холболт

Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт суурилуулах хяналтын камерын системийн сүлжээг шинээр зохион байгуулах бөгөөд сүлжээг Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын нэгдсэн сүлжээний 1-19 дүгээр хорооны чиглэлд тархсан шилэн кабелиар дамжуулан Чингэлтэй дүүрэг дэх Цагдаагийн 1 дүгээр хэлтэст 2, 5, 7, 8, 9 дүгээр хороо, Цагдаагийн 2 дугаар хэлтэст 11, 13, 14, 15, 16, 17, 18 дугаар хорооны хяналтын камерын сүлжээг төвлөрүүлэхээр зохион байгуулна.

Сүлжээний холболтын бүдүүвч

Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт суурилуулах хяналтын камерын системийн сүлжээний шилэн кабелин холболтыг дүүргийн нэгдсэн сүлжээний ашиглагдаагүй шөрмөсийг ашиглах, тухайн хяналтын камерын цэгт хамгийн ойр байрлах өмнө суурилуулсан хяналтын камерын сул шөрмөсийг ашиглан холбохоор зохион байгуулна. Сүлжээний урсгал нь 100/1000/40000 Мбит/сек байхаар зохион байгуулна.

СҮЛЖЭЭНИЙ ШААРДЛАГА

Сүлжээний ерөнхий шаардлага

- Сүлжээний үндсэн төхөөрөмжүүд нь **100/1000 mbps ethernet** сүлжээний төхөөрөмжүүд байна. Шилэн кабелин интерфэйс нь 100 Мбит/сек -ээс багагүй байна.
- Хяналтын камерын системийн сүлжээг Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар болон Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс хооронд **40000 mbps** сүлжээ үүсгэн Цагдаагийн хэлтсүүдийн хяналтын төвд холбохоор сүлжээний шийдлийг боловсруулна.
- Хяналтын камерын сүлжээ нь өргөтгөл, шинэчлэл, үйлчилгээ хийхэд тасалдал, саатал гарахгүй байхаар хяналтын камерын цэг бүр дээр багадаа 2 шөрмөсний нөөц сүлжээтэй байхаар зохион байгуулна.

Цахилгаан тэжээлийн шаардлага:

- Хяналтын камерын системийн тоног төхөөрөмжүүд нь хувьсах 220/240VAC 50 Нг, нэг фазын цахилгаан тэжээлээр ажиллана.
- Бүх тоног төхөөрөмж хяналтын камерын цэг, үндсэн хяналтын танхим, серверийн өрөө газардуулгын системд холбосон байна.
- Хяналтын камер суурилуулах шон нь аянга зайлуулагчтай байна.

Хяналтын камерын цэгт

- Байшин хороолол буюу дүүргийн 1-6 дугаар хорооны нутаг дэвсгэрт 6м өндөртэй 1.5 м урт гар дээр суурилуулсан байна.
- Гэр хороолол буюу дүүргийн 7-19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт суурилуулахдаа 9м өндөртэй 1.5 м урт гар дээр суурилуулсан байна.

- Төхөөрөмжийн хайрцаг нь 50*40*30 8 мм зузаантай төмөр хийц бүхий тоос шороо, ус чийгийн хамгаалалттай зориулалтын хайрцаг байна.
- Сүлжээний үндсэн төхөөрөмжүүд нь **100/1000 mbps ethernet** сүлжээний төхөөрөмжүүд байна.

ХЯНАЛТЫН КАМЕРЫН СИСТЕМИЙН ШААРДЛАГА

Дараах стандартуудыг ханган ажиллана.

- Барилга, орон сууц, гудамж талбайд тавих хяналтын камер. Ерөнхий шаардлага mns 6423:2013 стандарт
- Монгол улсын стандарт MNS 5207:2011 Шилэн кабелин суурилуулалт, Техникийн шаардлага
- MNS 62262 Гаднын механик нөлөөллийн эсрэг цахилгаан тоног төхөөрөмж ИК кодын хамгаалалтын зэрэг
- NEMA стандарт
- ONVIF стандарт
- MNS 2361: 1977 Дамжуулан нэвтрүүлэх радио зангилааны станц болон утсан холбооны суурин төхөөрөмжийн газардуулга

Хяналтын камерын ерөнхий шаардлага:

- Хяналтын камер нь дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүндтэй брэнд бүтээгдэхүүн байна.
- Үндсэн хөдөлгөөнт болон хөдөлгөөнгүй өргөн /180 градус/ хардаг камер байна.
 - Эргэдэг татдаг хөдөлгөөнт камер PTZ
 - 180 градусын өргөн өнцгөөр хардаг камер
 - Нэг чигийн гадна зориулалтын камер
- Хяналтын камерт нэгэн зэрэг 4 түүнээс дээш хэрэглэгч хандах боломжтой байх.
- Сүлжээгээр тэжээл PoE+ авдаг байна.
- Өөр дээрээ санах ойтой байна. Хяналтын төвийн үйл ажиллагаа тасалдсан тохиолдолд камер нь өөр дээрээ 72 цагаас багагүй хугацааны бичлэгийг хадгалж, сүлжээний холболт хэвийн болсон үед хяналтын төвийн систем рүү хуулбарладаг байх.
- Бүх төрлийн хяналтын камерын хувьд Монгол орны эрс тэс уур амьсгалд тохирсон (-) 40 С - (+)50С -д ажиллах чадвартай, Олон улсын NEMA 4X, IK-10, IP67 ба түүнээс дээш стандартыг заавал хангасан байна.
- Камерын хяналтын төвийн үйл ажиллагаа тасалдах, камерын сүлжээ тасрах тохиолдолд камер нь өөр дээрээ 7 хоногоос багагүй хугацааны бичлэгийг хадгалж, сүлжээний холболт хэвийн болоход бичлэгийг камерын хяналтын төв рүү дамжуулж хуулбарладаг байх
- Секундэд авах кадрын тоо нь дүрсний бүх хэмжээст 25-30 кадр байна.

Хөдөлгөөнт камер

Эргэдэг татдаг камер байна. /HIKVISION DS-2DF8250I5X-AEL дүйцэхүйц/

- Дүрсний мэдрэгч 1/2.8 CMOS байна.
- Дүрсний нягтрал 1920(H) * 1080(V) байна.
- Шуурхай санах ой/ 1024M/128M
- Хэвтээ тэнхлэгт 360 градус эргэдэг байх ба босоо тэнхлэгт 180 градус түүнээс, дээш байна.
- Оптик таталт 50x (түүнээс дээш) байна.
- Байгалийн гэрлийн орчинд тохирч ажиллах, өдөр шөнийн автомат функцтэй байна.
- Хэт улаан гэрэл (IR-Infra Red) ДЭМЖДЭГ, линзэндээ хэт улаан гэрлийн автомат хөшигтэй байна.
- IR DISTANCE 500M байна.
- Ажиллах хамгийн бага гэрлийн орчин нь: Хар цагаан горимд - 0.04 ЛЮКС, өнгөт горимд - 0.8 ЛЮКС эсвэл түүнээс дээш байна.
- Секундэд авах кадрын тоо нь дүрсний бүх хэмжээст 25-30 кадр байна.
- Дүрс хувиргаж сүлжээнд дамжуулах шахалтын горим нь H.264+, H.265+ Motion JPEG (M-JPEG) байна. IPv4/v6, HTTP, HTTPS, Qos болон бусад сүлжээний протоколуудыг дэмжиж ажилладаг байна.
- Хэрэглэгчийн нууц үг, IP хаягийн хязгаарлалт, HTTPS encryption болон IP67 гэх мэт хамгаалалттай байна.
- Хүйтний улиралд цахилгааны саатлаас болж төхөөрөмж хөлдөх эрсдэлтэй байдаг иймд цахилгаан сэргэхэд камер өөрийгөө хэвийн ажиллах температур хүртэл халаасны дараа асдаг байх, өөр дээрээ санах ойтой байх.

Хөдөлгөөнгүй камер

Хөдөлгөөнгүй камер байна. /HIKVISION DS-2CD2665G0-IZS дүйцэхүйц/

- Дүрсний мэдрэгч 1/2.4* 6 мегапиксель CMOS байна.
- Дүрсний нягтрал 6MP(3072x2048) байна.
- Секундэд авах кадрын тоо нь дүрсний бүх хэмжээст 25-30 кадр байна.
- 2.8-8мм эсвэл түүнээс дээш, 80-34 харах чадвартай, автомат DC-Iris, камерын фокусыг хяналтын төвөөс тохируулах боломжтой байна.
- Байгалийн гэрлийн орчинд тохирч ажиллах, өдөр шөнийн автомат функцтэй байна.
- Хэт улаан гэрэл (IR-infra Red) дэмждэг, линзэндээ хэт улаан гэрлийн автомат хөшигтэй байна.
- IR RANGE 50M байна.
- Маш бага гэрлийн орчинд ажиллах бүрэн чадвартай байна. Ажиллах хамгийн бага гэрлийн орчин нь: Хар цагаан горимд - 0.008 люкс, өнгөт горимд - 0.05 люкс эсвэл түүнээс дээш байна.
- Харанхуй орчинд дүрсийг сайн таних, хөдөлгөөнд ямар нэгэн сарнил

байхгүй байна. Хамгийн багадаа 0.008 люкс гэрлийн орчинд хөдөлгөөнийг мэдэрч ямар нэг сарнил, гацалт, хөдөлгөөний зууралт үүсэхгүй байна.

- Дүрс хувиргаж сүлжээнд дамжуулах шахалтын горим нь H.264, Motion JPEG (M.JPEG) байна.
- IPv4/v6, HTTP, HTTPS, QOS болон бусад сүлжээний протоколуудыг дэмжиж ажилладаг байна.
- Хэрэглэгчийн нууц үг, IP хаягийн хязгаарлалт, HTTPS encryption болон IP 67, IK10 гэх мэт хамгаалалттай байна.
- Өөр дээрээ санах ойтой байна.

Панаром камер

180 градусын өргөн өнцгөөр хардаг камер байна. / HIKVISION DS-2CD6986F-H дүйцэхүйц/

- Дүрсний нягтрал 7.3 мегапиксел 4096x1800 нягтаршилтай байна.
- 180 градусын өнцгөөр хардаг байна.
- Хөдөлгөөнт камертай хослон ажилладаг байна.
- Дүрсний мэдрэгч 1/1.8 CMOS байна.
- Секундэд авах кадрын тоо нь дүрсний бүх хэмжээст 25-30 кадр байна.
- 2.8-8мм эсвэл түүнээс дээш, 80-34 харах чадвартай, автомат DC-Iris, камерын фокусыг хяналтын төвөөс тохируулах боломжтой байна.
- Байгалийн гэрлийн орчинд тохирч ажиллах, өдөр шөнийн автомат функцтэй байна.
- Хэт улаан гэрэл (IR-infra Red) дэмждэг, линзэндээ хэт улаан гэрлийн автомат хөшигтэй байна.
- Маш бага гэрлийн орчинд ажиллах бүрэн чадвартай байна. Ажиллах хамгийн бага гэрлийн орчин нь: Хар цагаан горимд - 0.008 люкс, өнгөт горимд - 0.05 люкс эсвэл түүнээс дээш байна.
- Харанхуй орчинд дүрсийг сайн таних, хөдөлгөөнд ямар нэгэн сарнил байхгүй байна. Хамгийн багадаа 0.008 люкс гэрлийн орчинд хөдөлгөөнийг мэдэрч ямар нэг сарнил, гацалт, хөдөлгөөний зууралт үүсэхгүй байна.
- Дүрс хувиргаж сүлжээнд дамжуулах шахалтын горим нь H.265+/H.264+ triple-stream encoding, Motion JPEG (M.JPEG) байна.
- IPv4/v6, HTTP, HTTPS, QOS болон бусад сүлжээний протоколуудыг дэмжиж ажилладаг байна.
- Хэрэглэгчийн нууц үг, IP хаягийн хязгаарлалт, HTTPS encryption болон IP67, IK10, PoE+ гэх мэт хамгаалалттай байна.
- Өөр дээрээ санах ойтой байна.
- Хүйтний улиралд цахилгааны саатлаас болж төхөөрөмж хөлдөх эрсдэлтэй байдаг иймд цахилгаан сэргэхэд камер өөрийгөө хэвийн ажиллах температур хүртэл халаасны дараа асдаг байх, өөр дээрээ санах ойтой байх.

Хяналтын төв

Хяналтын нэгдсэн төв нь Чингэлтэй дүүргийн Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэст байрлана.

- Цагдаагийн 1, 2 дугаар хэлтсийн хяналтын камерын нэгдсэн төвөөс хорооны нутаг дэвсгэрт суурилуулсан бүх теле камеруудыг удирдаж нэгдсэн хяналт хийнэ.
- Мэдээлэл Шуурхай Удирдлагын Төвийн хяналтын системтэй уялдан ажиллах боломжтой байна.
- Хяналтын компьютер нь камер удирдах төхөөрөмжтэй Joystick/ -тэй байна.
- Нэгдсэн төв дэх серверийн өрөөг цагдаагийн байгууллагын мэдээлэл, холбоо, технологийн бодлого журмын 401,20-д заасан стандартын дагуу тохижуулна.
- Нэгдсэн удирдлагын менежментийн сервертэй байж болно.

БИЧЛЭГ ХАДГАЛАХ ТӨХӨӨРӨМЖ

Бичлэгийн төхөөрөмж нь 64 сувгийн буюу багадаа 64 камер оруулах, өргөтгөх боломжтой байх.


- 16 хүртэл хатуу диск нэмж өргөтгөх боломжтой байх
- Багадаа 2 сүлжээний оролттой байх
- HDMI гаралт, VGA гаралттай байх
- RAID 5, 6, 10 дэмжин ажилладаг байх
- Up to 6TB capacity for each HDD

БИЧЛЭГИЙН ПРОГРАММ ХАНГАМЖИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Албан ёсны лицензтэй программ хангамжтай байх ба 1 жилээс дээш хугацаанд үнэгүй **upgrade** хийх боломжтой байна. Хянах камерын тоог хязгааргүй өргөтгөх боломжтой байна. Бодит дүрсийг **25 mps** хурдтайгаар **32-оос** доошгүй камерыг, бичлэг үзэхдээ **25 mps** хурдтайгаар **20-оос** доошгүй камерыг хардаг байх. Серверүүд нь сүлжээний орчинд нэг сервер байдлаар ажилладаг байх. Виртуал дэлгэц хуваагчтай байна. Сервер тус бүрээс заагдсан камеруудыг нэг дэлгэц дээр гаргах боломжтой байх.

Сануулсан байрлалууд руу тодорхой хугацааны давтамжтайгаар автоматаар хардаг байхаар тохируулах функцтэй байх.

Joystick удирдлагын гар дэмждэг байх.



SOYON DREAM LIMITED

Date: 20190820


№ 52 / 2019

"АР БЭЛ АЛТАЙ" ХХК-д

Мэдэгдэл хүргүүлэх тухай.

Манай компани Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэр дэх орон сууц, гэр хороолол, авто зам, нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн гэрэлтүүлгийн ашиглалт засвар үйлчилгээг хариуцан ажилладаг бөгөөд Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт байрлах хяналтын камеруудыг "Ар Бэл Алтай" ХХК суурилуулах болсон тул, тус дүүргийн 19-н хорооны нутаг дэвсгэрт суурилуулсан гэрэлтүүлгийн шонгуудыг ашиглахыг зөвшөөрч байна.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Д.ЗОРИГТБААТАР

Silver center, 203
Chingeltei District
Ulaanbaatar, Mongolia

Mobile:(976)99089318
(976)99000172
Email:soyondream@yahoo.com